# 2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ОЙДОВЫН БАЛЖИННЯМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Нэг. Тохилог орчин

- Эрүүл тохилог орчинд сайхан амьдаръя

## Хоёр: Хүнд суртал

- Төрийн үйлчилгээг иргэн бүрт тэгш хүртээнэ

## Гурав. Ажлын байр

- Иргэн бүр үйлдвэрлэгч

## Дөрөв. Төсөв

- Төсвийн ил тод байдал, шилэн данс

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БОЛОВСРУУЛСАН: ОЙДОВЫН БАЛЖИННЯМ

2020.07.22

2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ОЙДОВЫН БАЛЖИННЯМЫН

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Нэг. Тохилог орчин**

Эрүүл тохилог орчинд амьдаръя

1.1. УИХ-д сонгогдсон гишүүдтэй Эрдэнэт хотын иргэд байгалийн баялагаас хүртдэг байх талаар хамтарч ажиллана.

1.2. Эрдэнэт хотын байгаль орчны бохирдол, хүн амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлууд, гол ус, хөрс, агаарын бохирдол, цагаан тоосыг арилгахад анхаарч холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.3. Эрдэнэт хотын авто зам, зогсоол, явган замыг өргөтгөж, нэвтрүүлэх чадавхийг дээшлүүлэх, хатуу хучилттай, сайжруулсан авто ба явган замыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

1.4. Эрдэнэт хотод дугуйн замтай болох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэж, эхлүүлнэ.

1.5. Нийтийн бие тамирыг дэмжиж иргэд чөлөөт цагаа өнгөрөөх, чийрэгжүүлэх талбай, тоглоомын талбайг хотын төвийн болон гэр хорооллын багуудаар нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

1.6. Гэр хорооллын иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яам, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлүүлнэ.

1.7. Хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.

1.8. Үер усны болзошгүй аюулаас хамгаалах, үерийн хамгаалалтын далан барих асуудалд онцгой анхаарч дэмжиж ажиллана

**Хоёр: Хүнд суртал**

Төрийн үйлчилгээг иргэн бүрт тэгш хүртээнэ.

2.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана

2.2. Эрдэнэт хотын эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах нөхцлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг нь шинэчлэх, эмч эмнэлэгийн ажилтнуудын чадавхийг сайжруулахад анхаарч ажиллана.

2.3. Хот хоорондын зорчигч тээврийн авто вокзалтай болох асуудлыг судлан ажил болгох ажлыг анхаарч ажиллана.

2.4. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгох, техник тоног төхөөрөмжтэй болгоход нь анхаарч дэмжиж ажиллана.

2.5. Иргэдийн аюулгүй байдалд анхаарч камержуулалтын системийг төгөлдөршүүлэх, хууль сахиулах онцгой чиг үүрэг бүхий байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр дэмжиж, бэлэн байдлыг хангуулахад хамтран ажиллана.

2.6. Үндсэн хуулийн шинэ өөрчлөлттэй холбогдуулан хотын соёлыг түгээхэд чиглэсэн залуусын дуу хоолой, санаачлагыг дэмжиж хамтран ажиллана.

2.7. Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг барьж байгуулсан илгээлтийн эзэд, анхдагч нарт хандсан бодлогыг шинэчлэн хэрэгжүүлнэ.
2.8. Ахмадууд, эмэгтэйчүүд, хүүхэд залуусыг дэмжсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Зорилтот бүлэг рүү хандсан дэмжлэгийг оновчтой хуваарилахад онцгойлон анхаарч ажиллана.
2.9. УИХ-аас баталсан хөгжлийн үзэл баримтлал болох “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нягт уялдан хэрэгжих юм.

## Гурав. Ажлын байр

3.1. Иргэдийн амьжиргааг дэмжиж орлого багатай хэсэгт чиглэсэн дэд хөтөлбөр боловсруулж тэдний өөрсдийнх нь идэвхи санаачлагыг дэмжиж ажиллана.
3.2. ЖДҮ-ийн болон бусад орон нутаг дахь дэмжлэгийн сангуудын үйл ажиллагааг олон нийтэд ил тод хүртээмжтэй байхад анхаарч дэмжиж ажиллана
3.3. Иргэдийг ажлын байраар хангах, хувийн хэвшлийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлж ажиллана
3.4. Орон нутгийнхаа бизнес эрхлэгчдийн зах зээлийг хамгаалахад бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

## Дөрөв. Ил тод байдал

4.1. Төсвийн хуваарилалт, гүйцэтгэлийн хяналт

4.2. Төсвийн санхүүгийн сахилга батыг сайжруулах

МӨРИЙН ХӨТӨЛБӨР
БОЛОВСРУУЛСАН: О.БАЛЖИННЯМ

2020.07.21